



ОРХОН АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРООНД

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.07.31 № 229
танай -ны № -т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Орхон аймгийн Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 – 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 – 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн

2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Орхон аймгийн Монгол Ардын намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцооор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Намын мөрийн хөтөлбөр хуудсыг хавсаргав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ



**ОРХОН АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМААС ОРОН НУТГИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР
(2024-2028)**

УРИА: “НИЙГМИЙН АРДЧИЛАЛ-ХҮНИЙ ХӨГЖИЛ”

Нэгдүгээр бүлэг: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Эрүүл мэнд

1.1.1 Аймгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог төлөвшүүлж, иргэдийн дундаж наслалтын хүсийн ялгаатай байдлыг багасгах бодлого хэрэгжүүлнэ.

1.1.2 Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын түншлэлийг өргөжүүлж, эрүүл мэндийн даатгалын байгууллагын уялдааг ханган, хяналтын тогтолцоог сайжруулна.

1.1.3 “Цахим эрүүл мэнд” хөтөлбөр хэрэгжүүлж, хяналтын тогтолцоог сайжруулан, иргэдэд учирч болзошгүй санхүүгийн болон эрүүл мэндийн эрсдэлээс сэргийлнэ.

1.1.4 “Эмч” хөтөлбөрийг үргэлжлүүлж, эрүүл мэндийн салбарын ажилтны мэдлэг, ур чадвар дадлыг хөгжүүлэн харилцаа хандлагыг сайжруулж, нийгмийн баталгааг хангах тусгай бодлого хэрэгжүүлнэ.

1.1.5 Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын барилга, байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан, дэвшилтэд технологи нэвтрүүлэх, стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.

1.2 Боловсрол

1.2.1 Боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэйгээр зохион байгуулж, хүүхдийг дарамт хүчирхийллээс анgid байх таатай орчныг бүрдүүлэн, иргэдийг насан туршийн боловсролд хамруулан, тасралтгүй суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.

1.2.2 “Багш” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил төлөвшлийг хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлстэй шүтэлцүүлэн, орон нутагт олон улсын жишигт нийцсэн хөтөлбөрөөр сургалт явуулж байгаа сургуулиудыг дэмжинэ.

1.2.3 Хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулан, сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын сургалтын агуулга, стандарт, чанарыг дээшлүүлж, хүүхдийн цогц хөгжлийг дэмжин, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулан, хүүхдийг амьдралын зөв дадалтай болгоно.

1.2.4. Дээд боловсролын сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолборыг төрөлжүүлэн, Политехник коллежиудыг мэргэжлийн ялгавартайгаар хөгжүүлж, шинэ мэдлэг бүтээх, үйлдвэрлэх, инноваци гаргах, нэвтрүүлэх, үр өгөөжтэй технологи хөгжүүлэх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ.

1.2.5. Бүх шатны боловсролын байгууллагуудад шаардлагатай барилга байгууламж, тоног төхөөрөмж, биеийн тамирын заал, танхимаар хангаж, суралцагчдад сурч хөгжих ээлтэй орчныг бүрдүүлнэ.

1.3 Соёл, Спорт

1.3.1 “Бүх нийтийн соёлын боловсрол II” болон “Монгол урлаг дэлхийн тайзнаа” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, орон нутагт орчин үеийн симфони джаз оркестр байгуулахад анхаарч, хүний нөөцийг чадавхжуулан, аймгийнхаа соёлын орон зайн үнэ цэнт байдлыг өсгөнө.

1.3.2 Төр-иргэний хамтын ажиллагааны түншлэлд үндэслэж, соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтонох чадварыг хамгаалан, аймгийн нутаг дэвсгэрт түүх, соёлын үл хөдлөх дурсгал, соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, сурталчилж өвлүүлж хөгжүүлнэ.

1.3.3 Мэргэжлийн урлагийн байгууллагууд болон соёлын төвүүдийн менежментийг сайжруулж, материаллаг бааз, хөрөнгө оруулалт, иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэн аймгийн Музейн шинэ барилгыг барьж, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.3.4 Аймгийн хэмжээнд мэргэжлийн болон өвлийн спортыг хөгжүүлж, хүний нөөц, материаллаг баазаар ханган баг тамирчдыг дэмжиж, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэгсдэд үйлчилгээ үзүүлэх спортын заал, талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.5 Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, шинэ тутам хөгжиж байгаа цахим болон хотын (урбан) спортын орчин үеийн нөхцөл, төвлөрсөн байр, талбай бүхий дэд бүтцийг хөгжүүлнэ.

1.4 Нийгмийн хамгаалал, нийгмийн баталгаа

1.4.1 Нийгмийн бүлэг бүрт чиглэсэн үйлчилгээг үе шаттайгаар цахимд шилжүүлэн нээлттэй болгож, хүүхэд, залуучууд, гэр бүл, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, зорилтот болон нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн нийгмийн хамгааллын “Ач санах”, “Анхдагч”, “Залуучуудын хөгжлийн хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр” зэрэг бусад хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.4.2 Анхан болон лавлагаяа шатлалын оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлж, дэвшилтэд технологи нэвтрүүлснээр иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

1.4.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлж, тэдэнд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.

1.4.4 “Халамжаас хөдөлмөрт” бодлогыг хэрэгжүүлэн зорилтот бүлгийн иргэдийг тогтвортой ажилд зөвлөн чиглүүлж, ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрт хамруулна.

1.4.5 Баялагийн сан, нийгмийн даатгалын сангаар дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлээр иргэдийг орон сууцжуулан “Миний түрээсийн орон сууц”

болон “Миний ажилтан орон сууцтай”, хөтөлбөрүүдийн хүрээнд иргэдэд түрээслэх болон түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.5 Хөдөлмөр эрхлэлт

1.5.1 Шинээр зохистой ажлын байр, өндөр технологийн шинэ ажлын байр, бүтээмжийн эко систем /ажил олгогч систем/-ийг бий болгож, аймгийн хэмжээнд “Бүтээмжийн хувьсгал” санаачилгыг хэрэгжүүлэн ажилгүйдлийн түвшинг бууруулна.

1.5.2 Өрхийн үйлдвэрлэл, бичил бизнесийг дэмжих зорилтын хүрээнд ажлын байрыг нэмэгдүүлэн цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар иргэдэд нэмэлт орлого олох боломж олгох бодлого баримтална.

1.5.3 Асрахуйн эдийн засгийн хөгжлийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн эко системийг бүрдүүлж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдээ асарч буй болон зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

1.5.4 “Эрдэнэтчүүд-Эрдэнэтчүүддээ хайртай” хөтөлбөрийг үргэлжлүүлэн, хөдөлмөрийн бүтээмж, үр дунд суурисан цалин хөлс, ажлын үнэлгээний системийг нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалтыг бий болгоно.

1.5.5 Их дээд сургууль, коллежийн дэргэд “Хөдөлмөр эрхлэлтийн төв”-ийг бий болгож, оюутан залуучуудыг цагийн ажилд зуучлах, цаг, өдрөөр ажиллах ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, залуучуудын хөдөлмөр үйлчилгээний загвар төв (startup)-ийг дэмжиж ажиллана.

Хоёрдугаар бүлэг: ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1. Төсвийн бодлого

2.1.1 Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, олон тулгуурт эдийн засагтай, үйлдвэрлэгч хот болно.

2.1.2 Улсын төсөвт төвлөрүүлж буй хөрөнгөнөөс аймгийн болон хойд бүсийн хөгжлийн стратегийг хангах шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг санхүүжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

2.1.3 Дижитал эдийн засгийг хөгжүүлж, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг нэмэгдүүлнэ.

2.1.4 Бүс орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдмэл цогц байдал, харилцан уялдааг хангана.

2.1.5 Өндөр технологид сууриссан, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, оролцогч талуудыг мэдээллээр ханган, төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан ногоон эдийн засгийг хөгжүүлнэ.

2.2. Үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн бодлого

2.2.1 Байгаль орчинд ээлтэй уул уурхайг хөгжүүлж, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.

2.2.2 Өндөр технологи, хиймэл оюун ухаан, их өгөгдөл суурилсан үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2.3 Барилгын үйлдвэрлэл, тоног төхөөрөмж ба бусад төрлийн метал /зэс/, резинэн хийцийн эд ангийн үйлдвэрлэлийг дэмжсэн төслүүдийг хэрэгжүүлнэ.

2.2.4 Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортод чиглэсэн мах, сүү, арьс, шир, ноос, ноолуур, дайвар бүтээгдэхүүний эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

2.2.5 Аймгийн хэмжээнд хүнсний үйлдвэрлэлийн нэр төрлийг нэмэгдүүлж, хүн амыг орон нутгийн эрүүл, баталгаат хүнсээр хангах бодлого баримтална.

2.3. Үйлчилгээний салбарын хөгжлийн бодлого

2.3.1 Нийтийн аж ахуйн үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, зардлыг бууруулан, ухаалаг систем нэвтрүүлж, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, санхүүгийн болон хүний нөөц, цалин хөлсний оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3.2 Аймгийн хэмжээнд хүнсний бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг хангах үе шаттай бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3.3 Орон нутагт худалдаа, нийтийн хоолны үйлчилгээний чанарыг сайжруулж, стандартыг мөрдүүлэх ажилд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дэмжинэ.

2.3.4 Аймгийн хэмжээнд **ахуй** үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.3.5 Банк санхүүгийн үйлчилгээнд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих, санхүүжилтийн эх үүсвэрийг тэлэх бодлого баримтална.

2.4. Түлш, эрчим хүч

2.4.1 Хойд бүсийн эрчим хүчиний найдвартай ажиллагааг хангах хүрээнд Эгийн голын усан цахилгаан станцыг барих асуудлыг бодлогын түвшинд оролцогч талуудтай хамтран ажиллана.

2.4.2 Орхон аймгийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлж, эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

2.4.3 Сэргээгдэх эрчим хүчиний эх үүсвэрүүдийг ашиглах бодлого баримталж, орон нутагт эрчим хүчийг хуримтлуулж ашиглах төслийг эхлүүлнэ.

2.4.4 Ахуйн хэрэглээний түлээ, нүүрсний хэрэглээний менежментийг сайжруулна.

2.4.5 Хотын инженерийн шугам сүлжээнд ухаалаг систем нэвтрүүлж, найдвартай байдал, хангамж, хүртээмж, засвар, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, хүний нөөцийг хангах нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ.

2.5. Зам, тээвэр, холбоо

2.5.1 Нийтийн тээврийн үйлчилгээнд иргэдийн тав тухтай байдлыг хангаж, найдвартай, аюулгүй, хямд, шуурхай, хүртээмжтэй, ухаалаг, хяналттай байх зарчмыг хэрэгжүүлнэ.

2.5.2 “Таван тойрог” авто замын төсөлд хамрагдаж, хил залгаа бүсийн төв, сумдтай хатуу хучилттай авто замаар холбогдоно.

2.5.3 Авто замын эвдрэлд хийх үнэлгээг тогтмолжуулан, урьдчилсан засвар, арчилгаатай авто замын сүлжээ байгуулна.

2.5.4 Орхон аймгийн тээвэр ложистикийн цогцолборыг кластераар хөгжүүлж, хүсэлт гаргасан хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.

2.5.5 Олон улсын жишигт нийцсэн шуудан хүргэлтийн тогтолцоог бүрдүүлж, үйлчилгээнд ухаалаг технологи нэвтрүүлнэ.

Гуравдугаар бүлэг: ХОЙД БҮСИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО-ЭРДЭНЭТИЙН ХӨГЖИЛ

3.1 Хүнд аж үйлдвэрийн хөгжлийн бодлого

3.1.1 Эрдэнэт хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г батлан хот төлөвлөлт, зам харилцаа, инженерийн дэд бүтэц, гэрэлтүүлгийг стандартын дагуу хийж, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлж, хотын соёлыг төлөвшүүлнэ.

3.1.2 Аймгийн газар зохион байгуулалтын 2037 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж, барилга байгууламжийн ашиглалтын төлөв, газар хөдлөлтийг тэсвэрлэх байдлыг тодорхойлох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.1.3 Эрдэнэт үйлдвэрт ~~Үйлдвэрлэл, Технологийн Парк~~ байгуулах бодлогыг дэмжин, шат дараатай хэрэгжүүлнэ.

3.1.4 Молибдений баяжмал боловсруулах үйлдвэр, Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах Катодын зэсийн үйлдвэр байгуулах, Засвар Механикийн Заводын өргөтгөлийн төслүүдийг хэрэгжүүлж экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжинэ.

3.1.5 Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр, Уул уурхай-металлургичийн үйлдвэрийн цогцолбор барих ажлыг үргэлжлүүлнэ.

3.2 Хойд бүсийн доторх болон бүс хоорондын хамтын ажиллагааны бодлого

3.2.1 Бүс нутгийн эдийн засгийн төрөлжилтэд нийцсэн хөнгөн аж үйлдвэрийн кластерийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлж, шинэ суурьшлын бүс байгуулах асуудлаар хамтран ажиллана.

3.2.2 Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын худалдан авалт, хангамжийн үйл ажиллагаанд орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.2.3 “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

3.2.4 Эрдэнэт үйлдвэрийн нөөц боломжид суурилан улс, бүсийн хэмжээнд хөдөө аж ахуйн салбарын механижуулалт, технологижих нөхцөлийг хангах дэд бүтцийг хөгжүүлнэ.

3.2.5 Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангаж, жимс, жимсгэний агро ойн аж ахуй хөгжүүлж, иргэдийг эрүүл, чанартай эко бүтээгдэхүүнээр хангана.

3.3 Хөдөөгийн хөгжлийн сэргэлтийн бодлого

3.3.1 “Хоршоо хөгжүүлэх үндэсний хөтөлбөр III” –ыг орон нутагт хэрэгжүүлж, мал аж ахуйн чиглэлээр суурин, хагас суурин фермерийн аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэдэд газар олгох асуудлыг шийдвэрлэнэ.

3.3.2 Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүсийн дотоод нөөцийг бүрэн ашиглан түүхий эд бэлтгэлийн төвүүдийн зах зээлийн нэгдсэн интеграцид нэгдэнэ.

3.3.3 “Малын эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, эрчимжсэн мал аж ахуй, мал, амьтны тэжээлийн үйлдвэрлэл хосолсон нэгдсэн аж ахуйг хөгжүүлж, мал эмнэлгийн лабораторийн чадавхыг сайжруулж, малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээтэй жишиг хоршоодыг төрүүлнэ.

3.3.4 Зах зээлд өндөр үнэ цэн бүхий бүтээгдэхүүнийг нийлүүлэх, хүлэмжийн аж ахуй болон бусад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүнсний төрөлжсөн зоорийн аж ахуйг нэмэгдүүлнэ.

3.3.5 Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтвортжуулан хөгжүүлж, хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана.

3.4 Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бодлого

3.4.1 Аялал жуулчлалын загвар бусынуга болох бодлогын хүрээнд аймгийн онцлогт тохирсон бренд бүтээгдэхүүнийг хөгжүүлнэ.

3.4.2 Эрдэнэт хотыг төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх болон Улаанбаатар, Хөвсгөл, Булган, ОХУ чиглэлийн аялал жуулчлалын түшиц газар болгоно.

3.4.3 Соёлын, эрүүл мэндийн, түүх угсаатны, спортын, үйл явдлын аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын ажиллагсдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, үйлчилгээний соёлыг сайжруулж, стандартын түвшинд үйл ажиллагаа явуулах ажлыг эрчимжүүлнэ.

3.4.4 “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-III” хөтөлбөрийг хэрэгжүүлж, аялал жуулчлалын үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, хүний нөөцийг чадавхжуулна.

3.4.5 Уран бүтээлчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлнэ.

3.5 Шинжлэх ухаан, инновац, технологийн дамжуулалт

3.5.1 Өндөр технологи, хиймэл оюун ухаан, их өгөгдөл суурилсан үйлдвэрлэлийг дэмжиж, мэдээлэл харилцаа холбоо, технологийн дамжуулалтын бүтээмжийг нэмэгдүүлнэ.

3.5.2 Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн инноваци, интеграцийг хөгжүүлэн, логистикийн сүлжээ байгуулах боломжийг бий болгоно.

3.5.3 Эрдэнэт үйлдвэр болон Шинжлэх ухаан технологийн паркийг түшиглэн сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн сүлжээ бий болгох, инновацийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах дэд бүтцийг байгуулан хөгжүүлж, мэргэшсэн ажилтнуудыг сургах ажлыг хамтран зохион байгуулна.

3.5.4 Инновацийн төсөл хэрэгжүүлэх хүрээнд технологийн парк, технологи дамжуулах төв, гарааны компани байгуулах, зах зээлд гарах, тэлэх, нээлттэй болох боломжийг бүрдүүлэн, эрдэмтэн судлаачид, иргэдийн ажлын үр дүнг дэмжиж урамшуулна.

3.5.5 “Цахим Эрдэнэт” хөтөлбөрийг шинэчлэн, хэрэгжүүлнэ.

Дөрөвдүгээр бүлэг: ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

4.1 Цахим засаглалын хөгжил

4.1.1 “Төрийн цахим үйлчилгээ” хөтөлбөр хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний цахим платформыг хөгжүүлнэ. /E-commerce, Цаг захиалгын систем, Dashboard, Ажил олгогчийн систем гэх мэт/.

4.1.2 Иргэдэд үзүүлж буй гол үйчилгээнүүдэд процессын шинжилгээ хийж цахимжуулах, автоматжуулах замаар иргэдэл төрөөс авах үйлчилгээний хугацаа, зардал хэмнэгдэнэ.

4.1.3 Төрийн үйлчилгээнд ухаалаг харилцаа /чатбот/-ыг нэвтрүүлнэ.

4.1.4 Төрийн байгууллагуудын хоорондын харилцаанд болон иргэдэд үзүүлэх үйлчилгээнд хиймэл оюун ухаан нэвтрүүлнэ.

4.1.5 Ухаалаг хотын стандартыг бий болгож төрдөнө.

4.2 Төрийн үйлчилгээний чанар хүртээмж

4.2.1 Төрийн үйлчилгээнд дахин инженерчлэл хийж шат дамжлагыг оновчтой болгож, үйлчилгээг хялбар дөхөм үзүүлнэ.

4.2.2 Орон нутагт төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоо, иргэний нийгэмд шилжүүлж, төрийн үйлчилгээний бүтээмж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.2.3 “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг шинэчлэн хэрэгжүүлнэ.

4.2.4 Нийгмийн түншлэлийн хүрээнд талуудын оролцоог нэмэгдүүлж, хяналтын тогтолцоог сайжруулна.

4.2.5 Төрийн байгууллагуудын нэгдсэн байрыг барьж төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг нэг дороос явуулах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

4.3 Нутгийн удирдлагын байгууллагын чадавх

4.3.1 Нутгийн удирдлагын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн ялгааг оновчтой тодорхойлж ажиллана.

4.3.2 Аймгийн хэмжээнд “Нутгийн удирдлагын засаглалыг сайжруулах хөтөлбөр” хэрэгжүүлнэ.

4.3.3 Нутгийн удирдлагын байгууллагын дотоод үйл ажиллагааны бодлогын шинэчлэл, Чанарын Нэгдсэн Удирдлага, үндэсний стандартыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудыг нэмэгдүүлнэ.

4.3.4 Аймаг, сумдын ЗДТГ-ыг үндэсний хэмжээний “Жишиг нутгийн захиргааны байгууллага” болгоно.

4.3.5 Нутгийн удирдлагын байгууллагын ил тод байдал, дотоод, гадаад хамтын ажиллагаа, зохицуулалт, хариуцлагын тогтолцоог сайжруулна.

4.4 Төрийн албаны хүний нөөцийн чадавх, нийгмийн баталгаа

4.4.1 Аймгийн хэмжээнд төрийн албаны хүний нөөцийн чадавх, хариуцлагын тогтолцоог сайжруулна.

4.4.2 “Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.4.3 Төрийн албан хаагчдын “Орон сууц” төслийг хэрэгжүүлнэ.

4.4.4 Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн дэмжиж ажиллана.

4.4.5 Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.

4.5 Хууль, эрх зүйн бодлого, хэрэгжилт, иргэдийн аюулгүй байдал

4.5.1 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлж, аймгийн хэмжээнд 5 ш ажиллагаанд хяналт тавьж, авлига, шударга бус үйлдлийн эсрэг тэмцэнэ.

4.5.2 Орон нутагт гамшигт үзэгдлүүд (ган, зуд, газар хөдлөлт, үер гэх мэт)-ийн тархалт давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг тогтмол явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.

4.5.3 Аюулгүй байдлын эрсдэлийн менежментийн чадавхыг бэхжүүлж, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг аймгийн хэмжээнд иж бүрэн нэвтрүүлж, иргэдийн аюулгүй орчинг бүрдүүлнэ.

4.5.4 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.5.5 Зайлшгүй шаардлагатай асуудлаар “Нээлттэй сонсгол”-ыг зохион байгуулж иргэдийн мэдэх эрхийг хангана.

Тавдугаар бүлэг: НОГООН ЭРДЭНЭТ-ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

5.1 Цаг уурын өөрчлөлт, сорилтыг даван туулах бодлого

5.1.1 "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлнэ.

5.1.2 Газрын хэвллийн зохистой ашиглалтыг сайжруулж, хөрсний бохирдлыг бууруулна.

5.1.3 Эрчим хүчний байгальд ээлтэй, хэмнэлттэй хэрэглээ, үр ашигтай дэвшилтэт ногоон технологийг дэмжиж, эдийн засгийн хөшүүргийг бий болгоно.

5.1.4 Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж, агаар, орчны чанарыг стандарт түвшинд хүргэж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.

5.1.5 "Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн, дэвшилтэд технологи нэвтрүүлж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан, эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.2 "Ус"-ны бодлого, хэрэгжилт

5.2.1 Усны хууль тогтоомжийн хэрэгжилтийг чангатгаж, хот, суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж, усны нөөц бохирдож, хомсдохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.2.2 Хүн амын ус хангамжийн системийн эх үүсвэрийн байгууламжтай болох ажлыг үе шаттай хэрэгжүүлэн, нөөцийг тогтоож, газрын доорх усны хэмжилтийн цэгийг нэмэгдүүлж, чанарын хяналт, мониторингийн сүлжээг өргөтгөнө.

5.2.3 Гадаргын ус, газрын тоогоц, голын гольдирлын хэв шинжийг ашиглан хур тунадас, хайлсан цас, месний усыг хуримтлуулах хэв цөөрөм байгуулна.

5.2.4 Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглан, усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, ус ашиглалтын үр ашиг, хэмнэлтийг сайжруулна.

5.2.5 Орхон аймгийн цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийг ашиглалтад оруулж, Жаргалант сумын ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэн өргөтгөнө.

5.3 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх бодлого, үйл ажиллагаа

5.3.1 Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

5.3.2 Ойг нөхөн сэргээх, ойн төгөл, ойн зурvas байгуулахад байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, мод үржүүлгийн газруудыг дэмжиж, шинээр байгуулах замаар тарьц, суулгацын хэрэгцээг хангаж, 20.0 сая ширхэг мод тарьж, ойн сангийн талбайг нэмэгдүүлнэ.

5.3.3 Цахим бүртгэлийн систем байгуулж, таримал мод, ногоон байгууламжийг бүртгэлжүүлнэ.

5.3.4 Мод, бут, сөөг тарьсан ногоон байгууламж нэмэгдүүлсэн, шинээр байгуулсан иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулах, бүртгэлийг цахимжуулна.

5.3.5 Аймгийн ойрхог чанарыг тогтмол нэмэгдүүлэх болдлогыг хэрэгжүүлнэ.

5.4 Хотын доторх болон гэр хорооллын ногоон хөгжил * /хаевралттай/

5.4.1 Орхон аймгийн нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн талбайн хэмжээг 4 дахин нэмэгдүүлж, түүний арчилгаа хамгаалалтыг хөгжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.

5.4.2 Олон зориулалтын ногоон байгууламж байгуулж "Шарилжгүй хот" төслийг хэрэгжүүлнэ.

5.4.3 Орон сууц болон гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг, зам талбай, шугам сүлжээ, камержуулалтыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

5.4.4 Ногоон байгууламжийн хайс, хашлагыг эдийн засгийн өртөг багатай, технологийн шинэлэг хэлбэрийг ашиглан өөрчилж, хамгаалалтын хашааг мод, бут, сөөгний тарилтын үйл ажиллагаатай уялдуулан хийнэ.

5.4.5 Хотын ногоон байгууламжийн арчилгаа хамгаалалтыг сайжруулахад зориулагдсан техник технологийг шинэчлэх, усалгааны шинэлэг систем нэвтрүүлнэ.

5.5 “Эрдэнэт үйлдвэр”-ийн Хаягдлын аж ахуйг шилжүүлэх үйл ажиллагаа:

5.5.1 “Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг эрчимжүүлнэ.

5.5.2 “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ⁶¹¹⁷¹⁴³⁶⁹⁰ аас⁰⁷ хаягдал өтгөрүүлэх технологийн ТЭЗҮ-г боловсруулж, 2027 онд ашиглалтад оруулах технологийн ажлыг эрчимжүүлнэ.

5.5.3 Хаягдлын аж ахуйг шилжүүлэхтэй холбоотой дэд бүтцийн асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.

5.5.4 Цагаан тоосны нөлөөллийн судалгааг давтамжтайгаар хийж, дүгнэлт гарган ажиллана.

5.5.5 Эрдэнэт үйлдвэр болон бусад үйлдвэрүүдийн байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж буй эсэхэд тогтмол хяналт тавьж цаашид үүсэх эрсдэлээс сэргийлнэ.

5.4*-ийн хавсралт

➤ ЖАРГАЛАНТ СУМ

- Эрүүл мэндийн төвийг өргөтгөж, иргэдэд хүргэх эрүүл мэндийн үйлчилгээний орчинг сайжруулна.
- Бохир ус цэвэрлэх байгууламжийг өртгөтгөнө.
- Техник дундын төвийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Айрагийн гозгорын археологийн малтлагыг үргэлжлүүлэн, аймгийн музей үзвэрийн санг баяжуулах зорилтыг дэмжинэ.
- “Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж, тариалангийн талбайн хөрсний үржил шиммийг сайжруулна.
- Гүний худгийн тоог нэмэгдүүлж, цахимжуулна.
- Төвийн орчны гэрэлтүүлэг, явган хүний замыг сайжруулж, камержуулна.
- Гэр хорооллын өрхийн нүхэн жорлонг цөөлж, эко 00-ийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- Өрхийн цахилгаан хангамжийн 6 кВ-ын ЦДАШ, 6/0.4 кВ-ын 160 кВА 3 дэд станц барих ажлыг үргэлжлүүлнэ.
- Төмс хүнсний төрөлжсөн зоорийн аж ахуйг нэмэгдүүлж, иргэдийн сүү, цагаан идээ, ногоо борлуулах менежментийг сайжруулна.
- Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулна.

➤ БАЯН-ӨНДӨР СУМ

- Зүүн бүс /Говил, Баянцагаан, Малчин/
 - Говил багт 250 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.
 - Баянцагаан багт УДТТөвийн барилга, гадна инженерийн шугамын хамт шинээр барих, УТБ-Т-1 шинэчлэн барих ажлыг эхлүүлнэ.
 - Говил багийн Хонхор хэсгийн наскилт дуусаж аваарын байдал үүссэн шугамыг шинэчлэн засварлах ажлыг эрчимжүүлнэ.
 - Говил, Баянцагаан багийн цэвэр усны шугам сүлжээг шинэчилнэ.
 - Баянцагаан багт байрлах 40 цагаан байрны 3.4-р эгнээний шугамыг шинэчлэн татах ажлыг үргэлжлүүлнэ.
 - Баянцагаан багт төмөр замын дагуу гарцын гүүртэй болгоно.
 - Хүүхдийн тоглоомын талбайг стандартад нийцүүлэн тохижуулна.
 - Түр хамгаалах байрны барилгын ажлыг эрчимжүүлнэ.

- Гэр хорооллын багийн төвүүд болон айл өрхийн төвлөрсөн шугам барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- Малчин багт худаг, уст цэгийг шинээр гаргах болон сэргээн засварлаж малчдад эзэмшүүлнэ.
- Гэр хорооллын өрхийн нүхэн жорлонг цөөлж, эко 00-ийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- Говил багийн 100 айлын орон сууцны дундуур үерийн шугам шинээр хийж, үерийн далантай холбоно.
- Баянцагаан багт 35/10 кВт-н дэд станцын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.
- **Өмнөд бүс /Дэнж, Эрдэнэ, Чингэл/**
- Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.
- Дахин төлөвлөлтийн иж бүрэн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, багийн төвүүд болон айл өрхийг төвлөрсөн шугам /халаалт, цэвэр, бохир/-д холбож барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг барих, засвар хийх ажлыг үргэлжлүүлнэ.
- Инженерийн шугам сүлжээг өргөтгэж, цахилгааны хүчдэлийг нэмэгдүүлнэ.
- Хүүхдийн тоглоомын талбайг стандартад нийцүүлэн тохижуулна.
- Багийн төвүүд, өрхийн төвлөрсөн шугам барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- Дэнж багийн 1,2,3 дугаар байрны орон сууцны зоорийн давхрын ариутгах татуургын, халаалт, халуун хүйтэн усны 5 хос шугам шинэчилнэ.
- Нийтийн тээврийн үйлчилгээний замыг уртасгаж, хатуу хучилттай замын өргөтгэл хийнэ.
- Өрхийн нүхэн жорлонг цөөлж, эко 00-ийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- Эрдэнэ, Чингэл баг /АТП-16/, Дэнж баг /АТП-62/ дэд станцын зүүн талд шинээр баригдах айл өрхийн цахилгаан хангамжийн 10 кВ-ын ЦДАШ, 10/0.4 кВ-ын 250 кВА /КТПН/ дэд станц барих ажлыг дуусгана.
- Эрдэнэ, Чингэл багт баригдах РП-3 10 кВ-ын хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажлыг хийнэ ~~9042806~~
- 35/10 кВ-ын Эрдэнэ дэд станцаас РП-3 10 кВ-ын 3.478 км хос кабель шугамын угсралтын ажлыг хийнэ.
- РП-2-аас 35/10 кВ-ын Эрдэнэ дэд станц хүртэлх 10 кВ-ын хос кабель шугамын угсралтын ажлыг хийнэ.
- Эрдэнэ, Чингэл багт АТП-18, АТП-48, АТП-60 дэд станцыг КТП болгож трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- Дэнж багийн цэвэр усны шугам сүлжээг шинэчилнэ.
- **Баруун бүс /Уртын гол, Их залуу, Яргуйт, Баян-Овоот, Шанд, Даваат, Рашаант, Наран, Цагаанчулуут, Найрамдал, Чандмань, Булаг, Баянбулаг/**
- Рашаант багт 250 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.
- Цахилгаан хангамж сайжруулах 6кВ-ын ЦДАШ, 6/0.4кВ-ын дэд станц барина.
- Өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг 2 тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх ажлыг эрчимжүүлж, гудамж хоорондын цахилгаан модон тулгууруудыг тэмэр бетонон шонгоор сольж, цахилгааны шугамыг өргөтгэн шинэчилнэ.
- Сансар худалдааны төв, ерөнхий боловсролын 3, 16 дугаар сургуулийн спорт заал барих ажлыг дуусгана.
- Хүүхдийн тоглоомын талбайг стандартад нийцүүлэн тохижуулна.

- Алслагдсан гэр хорооллын өрхийн эрүүл мэндийн төвүүдийг алсын болон зөөврийн оношилгооны /мобайл технологи/ нэвтрүүлнэ.
- Өрхийн нүхэн жорлонг цөөлж, эко 00-ийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 35/10 кВ-ын Булаг дэд станцаас 35/10 кВ-ын Даваат дэд станц хүртэлх 35 кВ-ын 2 хэлхээ 5 км ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг хийнэ.
- 35/10 кВ-ын 2x16 МВА Даваат дэд станцын барилга угсралтын ажлыг хийнэ.
- Даваат дэд станцаас Их залуу багт баригдах 10 кВ-ын РП-2 хуваарилах байгууламж хүртэлх 10 кВ-ын хос кабель шугамын угсралтын ажлыг хийнэ.
- 35/10 кВ-ын Даваат дэд станцаас Эрдэнэ дэд станц хүртэлх 35/10 кВ-ын 2 хэлхээ 12 км ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг хийнэ.
- Чандмань, Найрамдал багийн нэгдсэн байрыг барьж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулна.
- Уртын гол багт төлөвлөлтийн зураг схемийг гаргаж, шугам татна.
- **Төвийн бүс /Зэст, Оюут, Уурхайчин, Согоот, Уртбулаг, Бүрэнбүст, Хүрэнбулаг/**
 - 2A хороололд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг барьж ашиглалтад оруулна.
 - Хүүхдийн тоглоомын талбайг стандартад нийцүүлэн тохижуулна.
 - Орон сууцны хорооллын доторх 6/0.4кВ-ын дэд станцуудын трансформаторыг шинэчилнэ.
 - Зэст, Оюут, Уурхайчин багуудад УДТТөвүүдийн үл хамаарах схемд шилжүүлнэ. /ялтсан бойлерын бүрэн автомат цогц төхөөрөмж суурилуулах/
 - Оюут, Уурхайчин, Хүрэнбулаг, Даниста, Хангайн бүс худалдааны төв, Хүнсний захын ойролцоо УДТТөвийн дамжуулах, түгээх, цэвэр усны шугамыг шинэчлэх; барилга, гадна инженерийн шугамын хамт шинээр барина.
 - Зэст багт бохир ус татан зайлцуулах ATT-288-ATT-302 хүртэлх төв шугамыг шинэчилнэ.
 - 11-р хорооллын А, Г хэсэг, 2A хороололд 2x1000 кВА трансформатортой 2 дэд станц барина.
 - Бүрэнбүст, Уртбулаг, Согоот багуудад багийн байр барьж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - Хотын доторхи үерийн далан сувагт засвар шинэчлэл хийж, шаардлагатай цэгт шинээр суваг, авто машины орц, гарц гаргаж, хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлнэ.
 - Зэст, Оюут багийн дэд станцуудын РУ-6 кВ, РУ-0.4 кВ-ын тоноглол шинэчлэнэ.
 - Хүрэнбулаг багийн 22-р байрнаас 26-р байр хүртэлх, Зэст багийн 20, 21, Оюут багийн 11-а, б, 12-р байрны насжилт дуусч аваарын байдал үүссэн шугамыг шинэчилэн засварлаж дуусгана.
 - 11-р хорооллын төлөвлөлтийн зураг схемийг гаргаж, шугам татна.
 - Оюут багт 50 ширхэг худаг засварлана.
 - Төвийн багуудад усны ухаалаг тоолуур суурилуулна.
 - Орон сууцны зоорийн давхрын ариутгах татгуурын болон халаалт, халуун хүйтэн усны 5 хос шугам шинэчилж, гадна фасад дулаалах ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.
 - Зэст, Хүрэнбулаг, Согоот багуудад үерийн шугамыг өргөтгөх, үерийн худгуудад авто зам дээр трап хийнэ.

ОРХОН АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО